



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 6¹.1.5 дахь заалт нэмсүгэй:

“6¹.1.5.тээврийн хэрэгслийн өмчлөгчийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах;”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 6¹ дүгээр зүйлийн 6¹.1.5 дахь заалтын дугаарыг “6¹.1.6” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ